ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Их-Уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/152/НА-СТА-ТШЗ


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор: Б.Цэрэндэжид

Утас: 99812811

Цахим хаяг: tserendejid1109@gmail.com


Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
    2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
    2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
    2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
    2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
    2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга........8
    3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
    3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
    3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
    3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан........13
    4.1 Ерөнхий зүйл........13
    4.2 Материаллаг байдал........14
    4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........14
    4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал........14
    4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........15
    4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал........16
5. Аудитын илрүүлэлт........16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


---

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.11 № 78

танай________-ны №________-т

ИХ-УУЛ СУМЫН ХҮҮХДИЙН
НЭГДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ П.МӨНХТУУЛ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Их-Уул сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Их-Уул сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Их-Уул сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь 2024 онд Улсын төсвөөс 1,182,419.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 57,852.6 мянган төгрөгийн санхүүжилттэй, 178,699.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

Аудитын гол асуудал

Их-Уул сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 53 нэр төрлийн 49,973.3 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгөтэй, 1,219.6 мянган төгрөгийн зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 онд төсвийн хөрөнгөөр 7,334.1 төгрөгийн тавилга эд хогшил, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 20,000.0 мянган төгрөгийн төмөр хайс, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 40,531.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэнийг данс бүртгэлд тусгажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **207,575,885.03** | **308,956,984.24** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 88,980,426.37 | 178,699,357.58 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 88,980,426.37 | 178,699,357.58 |
| **3121** | **Төгрөг** | 88,980,426.37 | 178,699,357.58 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 88,980,426.37 | 178,699,357.58 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 118,595,458.66 | 130,257,626.66 |
| **351** | **Түүхий эд материал** | 55,155,311.66 | 64,618,361.66 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 55,005,311.66 | 64,333,361.66 |
| 35130 | Эм боох материал | 150,000.00 | 285,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 63,440,147.00 | 65,639,265.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,000,500.00 | 1,421,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 49,516,715.00 | 52,048,115.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 560,000.00 | 00.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 1,245,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 12,362,932.00 | 10,924,650.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,244,465,639.90** | **1,242,364,755.26** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,244,465,639.90 | 1,242,364,755.26 |
| 391 | Газар | 00.00 | 00.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,231,116,139.90 | 1,229,152,755.26 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,368,377,127.57 | 1,368,377,127.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -183,888,843.24 | -240,317,765.76 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 67,611,925.20 | 105,657,365.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -39,529,947.72 | -47,579,367.56 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 31,569,525.60 | 41,389,970.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -20,133,960.79 | -23,943,738.83 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,303,293.40 | 32,303,293.40 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -5,360,815.12 | -6,901,964.36 |
| 39217 | Ном | 167,835.00 | 167,835.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13,349,500.00 | 13,212,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,650,000.00 | 1,650,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,512,500.00 | -1,650,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,212,000.00 | 13,212,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,452,041,524.93** | **1,551,321,739.50** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **40,000.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 40,000.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 40,000.00 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 40,000.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,452,001,524.93** | **1,551,321,739.50** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,452,001,524.93 | 1,551,321,739.50 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 121,492,410.06 | 121,492,410.06 |
| 51101 | Өмч: - төрийн | 121,492,410.06 | 121,492,410.06 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,075,110,672.86 | 1,174,430,887.43 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,075,110,672.86 | 1,075,110,672.86 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 99,320,214.57 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 255,398,442.01 | 255,398,442.01 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,452,041,524.93** | **1,551,321,739.50** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **919,850,771.33** | **1,301,803,985.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **71,755,871.33** | **61,531,785.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 71,755,871.33 | 61,531,785.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **848,094,900.00** | **1,240,272,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 792,280,400.00 | 1,182,419,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 792,280,400.00 | 1,182,419,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 55,814,500.00 | 57,852,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 55,814,500.00 | 57,852,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **850,960,954.10** | **1,202,483,770.43** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **850,960,954.10** | **1,202,483,770.43** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 850,951,739.46 | 1,191,723,369.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 528,177,635.87 | 830,192,723.30 |
| 210101 | Үндсэн цалин | 367,354,439.08 | 535,020,580.56 |
| 210102 | Нэмэгдэл | 145,523,769.03 | 272,479,479.11 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 15,299,427.76 | 22,692,663.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,128,189.76 | 103,888,545.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,438,454.25 | 71,301,853.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,463,194.80 | 8,388,441.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,370,775.85 | 4,194,220.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,077,943.26 | 4,000,805.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,777,821.60 | 16,003,223.91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49,843,285.36 | 52,159,299.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,366,485.36 | 8,729,844.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,476,800.00 | 43,189,455.25 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 240,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 48,362,168.45 | 23,762,680.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,224,400.00 | 6,316,910.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,711,756.00 | 2,282,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 44,426,012.45 | 15,163,770.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 84,778,954.00 | 105,895,882.00 |
| 210502 | Хоол, хүнс | 84,778,954.00 | 105,895,882.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 17,770.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 17,770.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,387,200.00 | 1,982,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,387,200.00 | 1,982,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 70,274,306.02 | 73,824,269.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,583,000.00 | 3,857,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 65,691,306.02 | 69,966,769.64 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 9,214.64 | 10,760,400.75 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 10,760,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 10,760,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 9,214.64 | 00.75 |

| | | | |
|---|---|---|---|
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,214.64 | 00.75 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 68,889,817.23 | 99,320,214.57 |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *<br>/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **848,094,900.00** | **1,240,272,200.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **848,094,900.00** | **1,240,272,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 792,280,400.00 | 1,182,419,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 792,280,400.00 | 1,182,419,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 55,814,500.00 | 57,852,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 55,814,500.00 | 57,852,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **759,311,725.63** | **1,143,219,168.79** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **759,311,725.63** | **1,143,219,168.79** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **759,302,510.99** | **1,132,458,768.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 528,137,635.87 | 830,232,723.30 |
| 210101 | Үндсэн цалин | 367,314,439.08 | 535,060,580.56 |
| 210102 | Нэмэгдэл | 145,523,769.03 | 272,479,479.11 |
| 210104 | Урамшуулал | 15,299,427.76 | 22,692,663.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,128,189.76 | 103,888,545.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,438,454.25 | 71,301,853.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,463,194.80 | 8,388,441.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,370,775.85 | 4,194,220.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,077,943.26 | 4,000,805.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,777,821.60 | 16,003,223.91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49,873,285.36 | 51,920,599.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,341,401.36 | 7,689,244.00 |
| 210302 | Түлш, халаалт | 41,426,894.00 | 43,598,855.25 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,104,990.00 | 632,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 82,649,100.00 | 104,297,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 82,649,100.00 | 104,297,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,932,000.00 | 5,932,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,932,000.00 | 5,932,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,375,800.00 | 3,759,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,375,800.00 | 3,759,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23,206,500.00 | 32,427,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,079,200.00 | 21,576,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,127,300.00 | 10,851,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **9,214.64** | **10,760,400.75** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 10,760,400.00 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| +C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 121,492,410.06 | 255,398,442.01 | 1,075,110,672.86 | 1,452,001,524.93 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 121,492,410.06 | 255,398,442.01 | 1,075,110,672.86 | 1,452,001,524.93 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 121,492,410.06 | 255,398,442.01 | 1,075,110,672.86 | 1,452,001,524.93 |
| D01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 121,492,410.06 | 255,398,442.01 | 1,075,110,672.86 | 1,452,001,524.93 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 121,492,410.06 | 255,398,442.01 | 1,075,110,672.86 | 1,452,001,524.93 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 99,320,214.57 | 99,320,214.57 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 121,492,410.06 | 255,398,442.01 | 1,174,430,887.43 | 1,551,321,739.50 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 88,980,426.37 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,289,606,400.00** | 1,092,700,668.79 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,289,606,400.00** | 1,092,700,668.79 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,289,606,400.00** | 1,092,700,668.79 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,005,355,600.00 | 830,232,723.30 |
| 210101 | Үндсэн цалин | 692,353,600.00 | 535,060,580.56 |
| 210102 | Нэмэгдэл | 301,342,500.00 | 272.479.479,11 |
| 210104 | Урамшуулал | 11,659,500.00 | 22,692,663.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 116,447,700.00 | 103,888,545.49 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 79,186,800.00 | 71,301,853.42 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,313,500.00 | 8,388,441.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,657,800.00 | 4,194,220.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,657,800.00 | 4,000,805.77 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,631,800.00 | 16,003,223.91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51,920,600.00 | 51,920,599.25 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,057,500.00 | 7,689,244.00 |
| 210302 | Түлш, халаалт | 42,824,700.00 | 43,598,855.25 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,038,400.00 | 632,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 107,763,100.00 | 104,297,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 107,763,100.00 | 104,297,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | |
| 210604 | Урсгал засвар | 5,932,000.00 | 5,932,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,759,800.00 | 3,759,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 45,519,800.000 | 39,761,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,668,700.00 | 28,910,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,851,100.00 | 10,851,100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,289,606,400.00 | 1,182,419,600.00 |
| | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,289,606,400.00 | 1,182,419,600.00 |
| | **Нэг удаагийн тэтгэмж урамшуулал** | 10,760,400.00 | 10,760,400.00 |
| **1310** | Улсын төсвөөс санхүүжих | 1,289,606,400.00 | 1,182,419,600.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | | |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 57,852,600.00 | 57,852,600.00 |
| 4 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 88,980,426.37 |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 178,699,357.58 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 35 | 35 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 22 | 22 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13 | 13 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Их-Уул сумын 1-р цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл:***

- *Сургуулийн өмнөх боловсрол олгох*

***Их-Уул сумын 1-р цэцэрлэгийн зорилго:*** *Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд оршино.*

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Их-Уул сумын 1-р цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Татварын тухай хууль
11. Боловсролын тухай хууль
12. Төрийн хэмнэлтийн тухай хууль
13. Дотоод журам
14. СӨБ-ийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын

багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Их-Уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Их-Уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 99,280.2 төгрөгөөр буюу 1.07 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 118,595.5 | 130257.6 | 11,662.1 |
| Үндсэн хөрөнгө | 1,494,891.7 | 1,562,757.6 | 67,865.9 |
| **Нийт хөрөнгө** | **1,613,487.2** | **1,693,015.2** | **79,528.0** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **1,613,487.2** | **1,693,015.2** | **79,528.0** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,613,487.2** | **1,693,015.2** | **79,528.0** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлага байхгүй.

Бараа материалын эхний үлдэгдэл 118,595.5 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 141,880.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 130,218.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 130,257.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,662.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 3,334.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 40,531.8, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 20,000.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 1,562,757.6 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 69,966.8 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 79,528.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,182.419,2 мянган төгрөг, нийт зарлагыг 1,092,700.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,150,553.3 мянган төгрөг буюу 92.7 хувьтай байна. Энэ нь цалин НДШимтгэлийн зардлаас 135,558,285.2, хангамж ,бараа материалын зардлаас 3,449.1 , нормативт зардлаас 3,445.7 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих** | | | | | |
| **71801** | **Сургуулийн өмнөх боловсрол** | | | | |
| 80233 | Хүүхэд хамгаалал | 1,678.6 | 1,678.6 | 0.00 | 100% |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 2,483.2 | 2,483.2 | 0.00 | 100 % |
| 81807 | Хоол хүнс | 106,654.3 | 103,208.6 | 3,445.7 | 96.7% |
| 81816 | Нөхөн хангалт-Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх | 4,382.8 | 4,382.8 | 0.00 | 100% |
| 81823 | Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 2,483.2 | 2,483.2 | 0.00 | 100 % |
| 81834 | Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө | 1,135,606.8 | 947,500.5 | 488,106,3 | 83,4% |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 26,099.9 | 26,099.9 | 0.00 | 100% |
| 80109 | ТЗШ-ийн | 57,852.6 | 57,852.5 | 0.75 | 99.9% |
| **НИЙТ** | | **1,240,272.2** | **1,150,553.3** | **178,699.4** | **92.7%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Нээлттэй тендер шалгаруулалт | Хүүхдийн 1-р цэцэрлэгийн хоол хүнс | 106,654.3 | 103,208.6 |
| 2 | Нээлттэй тендер шалгаруулалт | Хүүхдийн 1-р цэцэрлэгийн Гадна хайс ОНХС | 20,000.0 | 20,000.0 |
| 3 | Шууд гэрээ байгуулах | Бараа үйлчилгээ | 15,866.1 | 12,417.0 |
| 4 | Шууд гэрээ байгуулах | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,851.1 | 10,851.1 |
| 5 | Шууд гэрээ байгуулах | Нөхөн хангалтын зардал-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх | 4,382.8 | 4,382.8 |
| 6 | Шууд гэрээ байгуулах | Эрүүл мэндийн зардал | 2,483.2 | 2,483.2 |
| 7 | Шууд гэрээ байгуулах | Мэдээлэл технологийн зардал | 3,759.8 | 3,759.8 |
| | **ДҮН** | | **163,997.3** | **157,102,5** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчит 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Их-Уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд анхан шатны хяналт хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Их-Уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугээр сарын 31-ны өдрийн 23 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 1,202,483.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,037.2 мянган төгрөгөөр,

гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,527.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Их-Уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно..

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд зөвлөмж өгөөгүй, акт албан шаардлага аваагүй байна.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байгаагүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0 мянган төгрөгийн 1 алдаанд зөвлөмж өглөө.

***Залруулсан алдаа:***

Байхгүй

**Шийдвэрлэсэн байдал:** Байхгүй

**5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй**

**5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж**

***Илэрсэн алдаа:*** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 31 төрлийн 52,935.6 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул **"Өөрчлөлтгүй"** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 31 нэр төрлийн 52,935,695.00 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **1** | | | | | | **1** | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-01-21

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК ГЭРЭЭТ АУДИТОР Б.ЦЭРЭНДЭЖИД

Огноо: 2025-01-21